

# Банкуудын ипотекийн зээлийн тайлан

2017 оны 11 дүгээр сар


## ХУРААНГУЙ:

- Тухайн сард банкууд 747 зээлдэгчид 52.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгосноор ипотекийн зээлийн үлдэгдэл 4231.8 тэрбум төгрөгт, нийт зээлдэгчдийн тоо 92.9 мянгад хүрэв.
- Ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.4 хувь нь ОСИСТТБХ<sup>1</sup> зээл байна.
- Нийт зээлийн үлдэгдлийн 96.0 хувь нь хэвийн, 2.2 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.8 хувь нь чанаргүй зээл байна.
- Ипотекийн зээлийн 99.6 хувь нь төгрөгөөр олгогдсон байна.
- Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 11.3 хувь, дундаж хугацаа нь 18.0 жил байна.
- Орон нутаг дахь банкууд 175 зээлдэгчид 7.1 тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгосноор орон нутаг дахь банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 764.9 тэрбум төгрөгт харин зээлдэгчдийн тоо 25.2 мянгад хүрчээ.
- Орон нутаг дахь банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 18.1 хувь харин нийт зээлдэгчдийн 27.1 хувийг эзэлж байна.
- Хөтөлбөрийн хүрээнд нийт 27.4 тэрбум төгрөгийн зээл шинээр олгож, 2.6 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлэв.

## 1. Ипотекийн зээлийн үлдэгдэл

2017 оны 11 дүгээр сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өсч 4231.8 тэрбум төгрөгт<sup>2</sup> хүрчээ. Үүнээс орон нутагт олгосон ипотекийн зээлийн үлдэгдэл 764.9 тэрбум төгрөг байгаа нь нийт ипотекийн зээлийн 18.1 хувийг бүрдүүлж байна.

Зураг 1. Ипотекийн зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт




Зээлдэгчдийн тоо 92.9 мянгад хүрсний 72.9 хувь нь Улаанбаатар хотод, 27.1 хувь нь орон нутагт ногдож байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.4 хувь нь хөтөлбөрийн зээл (орон нутгийн зээлийн хувьд 79.0), 19.8 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр (орон нутгийн зээлийн хувьд 20.1), 2.8 хувь нь бусад эх үүсвэрээр (орон нутгийн зээлийн хувьд 0.9) олгосон зээл байна.

<sup>1</sup> ОСИСТТБХ: “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөр”. Үүнд жилийн 5 ба 8 хувийн хүүтэй зээл, эдгээр зээлд шилжүүлсэн зээл орно. Цаашид хөтөлбөр гэнэ.


<sup>2</sup> Үүнд хөтөлбөрийн хүрээнд МИК руу шилжүүлсэн зээлийг оруулж тооцсон болно.

**Зураг 2. Ипотекийн зээлийн үлдэгдлийн сарын өсөлт (санхүүжилтийн эх үүсвэрээр)**



Ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.3 хувиар өссөнийг эх үүсвэрээр задлан харвал хөтөлбөрийн зээл 0.2, банкуудын өөрийн эх үүсвэрийн зээл 0.18 нэгж хувиар өсөж, бусад эх үүсвэрийн зээл 0.05 нэгж хувиар буурсан байна.

**Зураг 3. Ипотекийн зээлийн үлдэгдэл, аймгуудаар**



ОНБ-уудын ипотекийн зээлийн үлдэгдлийг аймгуудаар авч үзвэл Орхон аймагт 15.7 хувь, Дархан-Уул аймагт 15.5 хувь, Дорноговь аймагт 8.9 хувь, Дорнод аймагт 7.4 хувь, Ховд аймагт 5.4, Увс аймагт 5.4 хувь нь ногдож байгаа бөгөөд эдгээр нь ОНБ-уудын салбарын нийт ипотекийн зээлийн 58.2 хувийг бүрдүүлж байна.

**Зураг 4. Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь**




Тайлант сарын эцсийн байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.9 хувь нь хэвийн, 2.2 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.9 хувь нь чанаргүй зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас өөрчлөгдөөгүй байна. 2017 оны 11 дүгээр сарын байдлаар хугацаа хэтэрсэн ипотекийн зээлийн 61.4 хувийг хөтөлбөрийн зээл, 35.2 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 3.5 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна. Хугацаа хэтэрсэн ипотекийн зээлийн 1.5 хувийг гадаад валютын зээл бүрдүүлж байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь 1.9 буюу өмнөх сараас өөрчлөгдөөгүй байна. Чанаргүй зээлийн 67.0 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 30.0 хувийг хөтөлбөрийн зээл, 3.0 хувийг бусад эх үүсвэрээр олгосон ипотекийн зээл бүрдүүлж байна. Гадаад валютаар олгосон зээлийн 26.3 хувь нь чанаргүй гэж ангилагдсан бөгөөд нийт чанаргүй зээлийн 5.8 хувийг бүрдүүлж байна.


**Зураг 5. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар**



ОНБ-уудын нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн<sup>3</sup> 98.1 хувь нь хэвийн зээл, 0.8 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 1.1 хувь нь чанаргүй зээл байна.

## 2. Тайлант сард олгосон зээл

**Зураг 6. Тайлант сард олгосон зээл**




Тухайн сард банкууд 52.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноос, 52.6 нь хувь хөтөлбөрийн, 47.4 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээл байв.

Хөтөлбөрийн хүрээнд нийт 27.4 тэрбум төгрөгийн зээл шинээр олгож, 2.6 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлэв.


<sup>3</sup> Үүнд МИК-д шилжүүлсэн зээлийг оруулж тооцоогүй болно.

**Зураг 7. Нэг зээлдэгчид ногдох тухайн сард олгосон дундаж зээл**



Нэг зээлдэгчид ногдох шинээр олгосон зээлийн хэмжээ 2017 оны 11 дүгээр сарын байдлаар 69.8 сая төгрөг байгааг байршлаар ялган харвал Улаанбаатар хотод 78.8 сая төгрөг, орон нутагт 40.6 сая төгрөг байна. Хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл дунджаар 73.7 сая төгрөг байгаа бол банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл дунджаар 66.1 сая төгрөг байна.

**Зураг 8. Тухайн сард шинээр олгосон, төлөгдсөн зээл**



Тухайн сард 38.0 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, төлөгдсөн зээлийн хэмжээ өмнөх сараас 3.1 хувиар буурчээ. Үүний 10.8 тэрбум төгрөг нь хугацаанаас өмнө төлөгдсөн байна.

### 3. Зээлдэгчдийн тоо

**Зураг 9. Тухайн сард зээл авсан зээлдэгчийн тоо**




Тайлант сард нийт 747 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас хөтөлбөрийн зээлд 373 зээлдэгч, банкны өөрийн эх үүсвэрийн зээлд 374 зээлдэгч хамрагдсан байна.

2017 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 92887 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 68701 нь хөтөлбөрийн зээлд, 20416 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 3770 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.

#### 4. Зээлийн хугацаа

Зураг 10. Ипотекийн зээлийн хугацаа



Тайлант сард банкууд 2-30 жилийн хугацаатай ипотекийн зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 18.0 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2017 оны 11 дүгээр сарын байдлаар 17.2 жил байна. Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 62.8 хувь нь 16-20 хүртэлх жилийн хугацаатай байгаа бол нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 74.9 хувь нь 16-20 хүртэлх жил, 21.1 хувь нь 11-15 хүртэлх жил, 21-27 хүртэлх болон 6-10 хүртэлх жилийн хугацаатай зээл тус бүр 2.0 хувийг эзлэж байна.

Орон нутаг дахь нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 16.6 жил байна.


#### 5. Зээлийн хүү

Зураг 11. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХ



2017 оны 11 дүгээр сард банкуудын шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 11.3 хувь байгаа нь өмнөх сарынхаас 0.2 нэгж хувиар өссөн байна. Хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн хүү 7.99 хувь байсан бөгөөд банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 14.9 хувь байлаа.


Зураг 12. Ипотекийн зээлийн үлдэгдлийн ЖДХ, аймгуудаар



2017 оны 11 дүгээр сард ОНБ-уудын олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 13.2 хувьтай байна. Тайлант сард ОНБ-уудын өөрийн эх үүсвэрээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 15.8 хувь байгаагаас Ховд (23.0 хувь), Увс (21.6 хувь), Завхан (21.6 хувь), Өмнөговь (20.3 хувь) аймгуудад хамгийн өндөр, Говь-Алтай (10.2 хувь), Баян-Өлгий (8.9 хувь) аймгуудад хамгийн бага хувьтай байна.

## 6. Барьцаа хөрөнгийн мэдээлэл


Зураг 13. Орон сууцны байршил, Улаанбаатар хот



Ипотекийн зээлийн үлдэгдлийн 81.9 хувь буюу 3466.9 тэрбум төгрөгөөр Улаанбаатар хотод, 18.1 хувь буюу 764.9 тэрбум төгрөгөөр орон нутагт байршилтай орон сууц худалдан авчээ.


Улаанбаатар хотод худалдан авсан орон сууцны 33.9 хувь нь Баянзүрх дүүрэг, 23.7 хувь нь Хан-уул дүүрэг, 22.7 хувь Баянгол дүүрэг, 8.6 хувь нь Сонгинохайрхан дүүрэг, 11.1 хувь нь бусад дүүргүүдэд байршилтай байна.

Зураг 14. Барьцаа хөрөнгийн байршил, орон нутаг




Орон нутагт худалдан авсан барьцаа хөрөнгийн 52.8 хувь нь хүн амын суурьшил харьцангуй их байдаг Орхон, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Ховд аймгуудад байршилтай байна.

Зураг 15. Барьцаа хөрөнгийн ашиглалтанд орсон он



Ипотекийн зээлийн үлдэгдлийн 61.2 хувь буюу 2587.9 тэрбум төгрөгөөр 2011-2015 онд, 13.9 хувь буюу 587.6 тэрбум төгрөгөөр 2016 оноос хойш, 11.6 хувь буюу 490.7 тэрбум төгрөгөөр 2001-2010 онд, 10.3 хувь буюу 434.6 тэрбум төгрөгөөр 1991 оноос өмнө ашиглалтанд орсон орон сууц тус тус худалдан авчээ.


Зураг 16. Барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ



Ипотекийн зээлийн үлдэгдлийн 90.7 хувь буюу 3839.1 тэрбум төгрөг 80м2 хүртэлх талбай бүхий орон сууц худалдан авахад зарцуулагджээ. 80 м2 хүртэл талбайтай зээлийн 85.2 хувийг хөтөлбөрийн эх үүсвэрээр, 12.3 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.5 хувийг бусад эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.

(\* 80м2-аас дээш талбай бүхий амины орон сууц болон хашаа байшинд хөтөлбөрийн эх үүсвэрээр зээл олгож байгаа болно.)

Зураг 17. Барьцаа хөрөнгийн төрөл




Ипотекийн зээлийн үлдэгдэлд нийтийн зориулалттай орон сууцны зээл 97.0 хувь, хашаа, байшингийн зээл 1.8 хувь, амины орон сууцны зээл 1.2 хувийг тус тус эзэлж байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 75.6 хувь нь нэмэлт барьцаагүй, 24.4 хувь нь нэмэлт барьцаатай зээл байгаа бөгөөд зээлдэгчийн 79.7 хувь нь буюу 74006 зээлдэгч худалдан авч буй орон сууцаа барьцаалан, нэмэлт барьцаагүйгээр зээл авсан байна.

## 8. Зээлдэгчийн мэдээлэл


Зураг 18. Зээлдэгчийн орлого



2017 оны 11 дүгээр сарын байдлаар ипотекийн зээлтэй нийт зээлдэгчдийн тоо 92889 байгаагийн 64.6 хувь нь 2 сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой бөгөөд 72.9 хувь нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авчээ. Худалдан авсан орон сууцных нь төрлөөр ангилан харвал зээлдэгчдийн 92.6 хувь нь нийтийн зориулалттай орон сууц, 6.1 хувь нь хашаа байшин, 1.4 хувь нь амины орон сууцанд зориулан ипотекийн зээл авсан байна.

Улаанбаатар хотод орон сууц худалдан авсан


**Зураг 19. Зээлдэгчийн орлого, барьцаа хөрөнгийн байршлаар, Улаанбаатар хот**



иргэдийн 32.6 хувь нь Баянзүрх, 23.4 хувь нь Баянгол, 19.9 хувь нь Хан-Уул, 12.1 хувь нь Сонгинохайрхан, 7.0 хувь нь Сүхбаатар, 2.8 хувь нь Чингэлтэй, 2.2 хувь нь алслагдсан дүүргүүдэд орон сууц авчээ.


Улаанбаатар хотод байршилтай орон сууцны зээлийн үлдэгдлийг дүүргүүдээр, орон сууц худалдан авсан иргэдийнх нь сарын орлогын түвшингээр нь ялган харвал Баянзүрх, Хан-Уул, Баянгол дүүргүүдэд орон сууц худалдан авсан зээлийн нийт ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хувь орлогын түвшин бүрт 76-аас дээш хувийг эзэлж байна.

**Зураг 20. Зээлдэгчийн орлого, барьцаа хөрөнгийн байршлаар, орон нутаг**



Орон нутагт ипотекийн зээлээр орон сууц худалдан авсан иргэдийг өрхийн сарын орлогын түвшингээр нь ялган харвал 2 саяаас дээш орлоготой иргэдийн 50-иас дээш хувь нь хүн амын суурьшил харьцангуй өндөр Орхон, Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймгуудад орон сууц худалдан авчээ. 2 сая хүртэлх орлоготой иргэдийн 54.9 хувь нь дээрх 4 аймгаас гадна Увс, Өвөрхангай, Ховд аймгуудад орон сууц худалдан авсан байна.

**Зураг 21. Зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл**




Нийт зээлдэгчдийн 76.3 хувь нь 25-45 насны иргэд байгаа бөгөөд эдгээр зээлдэгчид нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 80.0 хувийг эзэмшиж байна.

Бүх насны ангилал дахь иргэдийн 68.0-аас дээш хувь нь Улаанбаатар хотод орон сууц худалдан авчээ.




**Зураг 22.Зээлдэгчийн хөдөлмөр эрхэлж буй байгууллагын үйл ажиллагааны салбар**




Ипотекийн зээлтэй 92889 иргэдийн 20383 нь бөөний болон жижиглэн худалдаа эрхэлж, 18000 иргэн төрийн удирдлага, батлан хамгаалах, 6247 иргэн санхүү даатгал, 5164 иргэн уул уурхай, 4069 иргэн боловсрол, 4057 иргэн тээвэр агуулахын салбарт хөдөлмөр эрхэлж байна

**Зураг 23.Зээлдэгчийн хөдөлмөр эрхлэлтийн статус**



Нийт зээлдэгчдийн 85.4 хувь буюу 79320 нь цалин хөлстэй ажиллагч, 11.8 хувь буюу 10915 хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна.

**Зураг 24. Хамтран зээлдэгчийн тоо**



Зээлдэгчдийн 79.6 хувь нь нэг хамтран зээлдэгчтэй, 15.6 хувь нь хамтран зээлдэгчгүй, 4.9 хувь нь 2 болон түүнээс дээш хамтран зээлдэгчтэй байна. Нэг хамтран зээлдэгчтэй зээлдэгчид нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 79.8 хувь буюу 3378.2 тэрбум төгрөгийн зээлийг эзэмшиж байна.

### Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээл

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (жилээр)	Тухайн сард олгосон зээлийн жилийн ЖДХүү, (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	Үүнээс:
			ОСИССТБ хөтөлбөрийн зээл				ОСИССТБ хөтөлбөрийн зээлтэй
2012	12	845,204.4		13.0	15.3	29,887	
2013	12	1,938,945.3	1,248,633.8	16.1	9.9	48,320	30,600
2014	1	2,021,424.9	1,324,898.9	16.2	9.8	49,731	32,190
	2	2,121,802.6	1,382,084.1	16.1	9.9	53,611	33,346
	3	2,193,368.6	1,451,938.1	15.9	9.9	54,787	34,632
	4	2,280,503.5	1,538,506.8	16.0	9.8	56,137	36,081
	5	2,365,349.5	1,618,127.2	15.8	10.0	57,579	37,488
	6	2,440,007.1	1,684,583.9	15.2	10.5	58,793	38,659
	7	2,492,105.2	1,728,222.8	15.7	10.7	59,756	39,507
	8	2,553,827.2	1,780,078.3	15.6	10.5	60,851	40,405
	9	2,619,161.1	1,833,494.0	15.5	10.6	62,017	41,390
	10	2,703,792.6	1,903,636.6	15.8	10.4	63,652	42,772
	11	2,762,726.8	1,954,341.3	16.2	10.3	64,577	43,621
	12	2,844,706.3	2,027,952.9	16.7	9.9	66,334	45,283
2015	1	2,898,731.0	2,072,894.5	16.3	10.2	67,233	46,134
	2	2,949,116.5	2,121,339.7	16.6	9.7	68,126	47,108
	3	3,015,535.1	2,196,795.5	16.5	9.2	69,269	48,512
	4	3,082,551.7	2,263,794.5	16.6	9.6	70,498	49,691
	5	3,128,182.4	2,305,308.1	16.4	10.3	71,355	50,462
	6	3,192,029.1	2,363,999.7	16.4	9.6	72,412	51,438
	7	3,230,507.8	2,400,625.2	16.1	9.9	73,208	52,181
	8	3,267,175.5	2,433,968.6	16.3	10.0	73,949	52,858
	9	3,319,711.8	2,481,556.8	16.2	9.6	74,848	53,643
	10	3,370,510.2	2,534,505.4	16.8	9.4	75,877	54,612
	11	3,412,929.6	2,570,150.9	16.4	10.0	76,583	55,295
	12	3,432,957.6	2,590,987.6	16.7	8.8	77,105	55,830
2016	1	3,434,849.9	2,595,234.1	16.3	10.1	77,226	56,031
	2	3,459,596.6	2,623,837.0	16.6	9.2	77,673	56,577
	3	3,565,687.2	2,679,829.3	17.1	8.8	81,015	57,659
	4	3,625,870.6	2,751,292.4	16.7	8.2	82,156	59,001
	5	3,697,056.7	2,832,261.7	19.7	8.3	83,280	60,455
	6	3,792,276.2	2,929,375.2	19.1	7.7	84,906	62,080
	7	3,849,221.0	2,995,847.0	19.5	7.7	85,622	63,146
	8	3,886,362.9	3,029,623.4	19.0	8.4	86,221	63,729
	9	3,943,037.2	3,047,579.5	19.7	8.7	87,925	64,081
	10	3,950,186.6	3,052,251.0	18.1	9.1	88,044	64,277
	11	3,979,535.9	3,082,876.9	18.8	9.2	88,555	64,868
	12	4,018,298.5	3,115,908.9	18.6	10.3	89,156	65,412
2017	1	4,034,887.3	3,133,147.5	18.5	9.6	89,482	65,777
	2	4,062,800.9	3,158,120.1	18.2	10.3	89,823	66,166
	3	4,091,151.9	3,181,950.1	18.8	10.3	90,437	66,718
	4	4,112,246.3	3,199,452.5	18.0	10.5	90,850	67,076
	5	4,143,154.8	3,224,511.7	18.3	11.2	91,362	67,523
	6	4,177,179.5	3,224,764.8	18.0	11.4	91,916	67,894
	7	4,186,060.9	3,250,403.9	17.5	11.5	92,138	68,134
	8	4,196,170.0	3,256,238.4	17.6	12.0	92,347	68,311
	9	4,206,816.9	3,260,034.5	17.9	12.5	92,616	68,464
	10	4,217,734.6	3,267,075.0	18.6	11.1	92,706	68,545
	11	4,231,843.2	3,275,531.7	18.0	11.3	92,889	68,703

## Хавсралт 2. Банкуудын ипотекийн зээл, нийслэл, аймгуудаар

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТБХ-ийн зээл		Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл* (сая.төг)	Чанаргүй зээлийн үлдэгдэл* (сая.төг)	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жилийн ЖДХугацаа	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо	Үүнээс: ОСИСТБ хөтөлбөрийн зээлтэй
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь						
1 Улаанбаатар	3,466,904.8	81.9%	2,671,465.4	81.6%	35,446.6	50,328.5	220.1	11.0	67,723	51,259
2 Орхон	119,760.8	2.8%	104,010.4	3.2%	245.6	104.9	158.8	17.4	927	586
3 Дархан-Уул	118,368.3	2.8%	100,993.0	3.1%	605.9	560.5	188.9	9.6	572	437
4 Дорноговь	68,446.2	1.6%	55,438.2	1.7%	389.2	625.3	203.5	15.0	3,638	3,001
5 Дорнод	56,347.2	1.3%	47,974.4	1.5%	220.0	400.1	195.3	15.7	429	290
6 Ховд	41,339.4	1.0%	35,387.9	1.1%	179.0	407.9	189.8	17.2	3,071	2,599
7 Увс	41,249.6	1.0%	30,492.4	0.9%	995.0	2,361.1	185.5	14.2	692	199
8 Баянхонгор	39,348.1	0.9%	35,474.2	1.1%	360.1	195.2	154.4	8.9	1,140	343
9 Сэлэнгэ	34,031.9	0.8%	25,312.6	0.8%	296.8	407.8	229.1	9.8	497	312
10 Өвөрхангай	32,626.8	0.8%	23,058.2	0.7%	480.5	440.0	152.8	18.3	1,298	677
11 Өмнөговь	29,813.4	0.7%	21,397.1	0.7%	141.2	543.3	169.6	13.6	659	435
12 Сүхбаатар	26,599.3	0.6%	19,449.9	0.6%	254.6	91.0	140.2	13.1	1,354	751
13 Баян-Өлгий	24,771.1	0.6%	12,540.8	0.4%	622.0	388.7	161.2	13.2	1,288	1,094
14 Архангай	21,133.5	0.5%	17,333.1	0.5%	44.5	77.5	90.0	9.6	642	458
15 Хэнтий	20,601.5	0.5%	15,675.9	0.5%	147.0	169.3	120.0	21.6	550	210
16 Хөвсгөл	16,044.7	0.4%	8,554.9	0.3%	387.1	328.3	182.5	12.0	1,305	864
17 Говь-Алтай	15,767.7	0.4%	12,502.9	0.4%	83.5	81.5	247.5	8.8	1,853	1,455
18 Завхан	13,964.3	0.3%	7,903.5	0.2%	155.1	117.3	165.7	16.2	975	628
19 Төв	13,593.7	0.3%	9,203.5	0.3%	162.9	149.0	232.1	15.5	1,325	1,017
20 Дундговь	12,889.6	0.3%	9,820.7	0.3%	53.4	50.3	183.5	9.8	2,153	1,652
21 Говьсүмбэр	9,195.9	0.2%	7,075.3	0.2%	141.8	94.2	245.1	11.3	455	312
22 Булган	9,045.3	0.2%	4,467.6	0.1%	277.4	449.9	175.8	7.4	343	124
<b>Нийт</b>	<b>4,231,843.2</b>	<b>100.0%</b>	<b>3,275,531.7</b>	<b>100.0%</b>	<b>41,689.2</b>	<b>58,371.7</b>	<b>215.8</b>	<b>11.3</b>	<b>92,889</b>	<b>68,703</b>

\* Банкуудын баланс дахь хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдлийг харуулав. Үүнд "МИК ОССК" ХХК-д шилжүүлсэн зээлийн дүн ороогүй болно.